



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар Б/13

Цэнхэрмандал сум

Мөнгөн урамшуулал олгох тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Багшийн ажлын үнэлгээний үр дүнгээр 91.64 %-тай, индексийн түвшин III-д үнэлэгдсэн багш Б.Нандин-Эрдэнэд 2025 оны 4, 5-р сарын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн мөнгөн урамшууллыг бодож олгосугай.

2. Мөнгөн урамшууллыг тухайн кластер дахь багшийн эрэмбийн хувь $75 < M < 85$ харгалзуулан албан тушаалын үндсэн цалинг сар бүр 20 хувиар тооцож 5 дугаар сард олгохыг нягтлан бодогч Д.Ганчимэгт зөвшөөрсүгэй.

ЭРХЛЭГЧ



П.ГАНТУЯА